

## ДӨРӨВ. АЛСЫН ХАРАА

Алсын хараа нь аймгийн ирээдүйн хөгжлийн төлвийг тодорхойлсон үр дүн юм. Сэлэнгэ аймгийн алсын харааг тодорхойлохдоо аймгийн ирээдүйн талаарх төсөөлөл юу вэ?, Ирээдүй хойч үедээ юуг өвлүүлж үлдээх вэ?, Хүмүүсийн амьдралыг хэрхэн сайжруулах вэ? гэсэн гурван асуултыг чиг баримжаа болгосон.



### Алсын хараа

Эрчимжсэн хөдөө аж ахуйд суурилсан, байгальд ээлтэй үйлдвэрлэгч аймаг болно.

### Уриа

Бүтээлч оролцоо – Хөгжлийн тулгуур

---

## ТАВ. ЭРХЭМ ЗОРИЛГО

Эрхэм зорилго нь аймгийн одоо ба ирээдүйн хөгжлийн үзэл баримтлал, үнэт зүйл, оршин тогтнох учир шалтгааныг илэрхийлнэ. Сэлэнгэ аймгийн эрхэм зорилгыг тодорхойлохдоо бид юу хийдэг вэ? Хэнд зориулж үүнийг хийдэг вэ?, Яагаад үүнийг хийдэг вэ? гэсэн гурван асуултыг чиг баримжаа болгов.



### Эрхэм зорилго

Эрчимжсэн хөдөө аж ахуйг хөгжүүлэн эдийн засгаа тэтгэж, иргэдийн амьдралын чанарыг сайжруулах

### Үнэт зүйл

- *Хууль дээдлэх* – Үйл ажиллагаандаа хуулийг чанд сахин биелүүлэх, хуульд нийцсэн шийдвэр гаргах;
- *Ёс зүй, хариуцлагатай байх* – Ёс зүйн хэм хэмжээг чанд мөрдөх, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, нөлөөнд автахгүй байх, хариуцсан ажилдаа эзэн байх, тэгш шударга байх;
- *Ил тод байх* – Мэдээлэл нь олон нийтэд нээлттэй, ил тод, ойлгомжтой байх, тэгш хүртээмжтэй байх;
- *Мэдлэг, инновацийг эрхэмлэх* – Шинжлэх ухаанч, шинэ санаа, байгаль орчинд ээлтэй технологид тулгуурласан байх;
- *Мэргэисэн байх* - Ажил үүргээ мэргэжлийн өндөр түвшинд чадмаг, сурамгай, найдвартай гүйцэтгэх;
- *Бүтээлч оролцоо, хамтын ажиллагааг хангах* - Бүтээлч хөдөлмөр, идэвхи санаачилгыг өрнүүлэх, төр ба хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, иргэдийн оролцоог аймгийн хөгжилд чиглүүлэх;

## ЗУРГАА. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО

Сэлэнгэ аймгийн орчны шинжилгээний үр дүнг аймгийн цаашдын хөгжлийн стратегийг тодорхойлох үндэслэл болгов. Аймгийн 2022-2025 оны стратеги төлөвлөгөөний хүрээнд дараах стратегийн зорилгыг дэвшүүлэв. Үүнд:

Стратегийн зорилго 1	Ковидоос шалтгаалсан нийгэм, эдийн засгийн бэрхшээлийг давна.
Стратегийн зорилго 2	Байгаль орчны эмзэг байдлын индексийг зорилтот түвшинд хүргэнэ.
Стратегийн зорилго 3	1 хүнд ногдох ДНБ-ийг суурь түвшнээс 3 хувиар өсгөнө.
Стратегийн зорилго 4	Хүний хөгжлийн үзүүлэлтийг 0.704-д хүргэнэ.
Стратегийн зорилго 5	Засаглалын үнэлгээг суурь түвшнээс 10 пунктээр өсгөнө.
Стратегийн зорилго 6	Иргэдийн амар тайван, аюулгүй байдалд нөлөөлж болох эрсдэлийг бууруулна.

Сэлэнгэ аймгийн ЗДТГ

Төрийн захиргааны удирдлагын хэлтэс